



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 10 өдөр

Дугаар A/129

Улаанбаатар хот

「 Салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах  
төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Зам, тээврийн салбарын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хариуцсан чиглэлээр бүрэн хэрэгжүүлж, байгууллага тус бүрдээ өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг харьяа агентлаг, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. “Зам, тээврийн салбарын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан арга хэмжээ нэг бүрийн хэрэгжилт, салбар байгууллагынхаа хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах талаар авсан арга хэмжээ, үр дүн, цаг үеийн нөхцөл байдлын талаар мэдээ, тайланг сар бүрийн 25-ны өдрийн дотор Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсэгт ирүүлж байхыг харьяа агентлаг, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Зам, тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах Ажлын хэсгийн дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.



Л.ХАЛТАР

08 000000

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн  
А/1129 дугаар тушаалын хавсралт,

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН 2021-2022 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ НЭГДСЭН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа (он, сараар)	Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр (сая төгрөг)	Хэрэгжүүлэх байгууллага
1	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
<b>НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР</b>				
1.	Байгууллагын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах, хяналт тавих, дүгнэн ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг томилон ажиллуулж, байгууллагын өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөг батлан, мөрдөж ажиллах;	2021 оны 08 дугаар сарын 10-ны дотор	-	Салбарын бүх байгууллага
2.	Төв болон орон нутгийн салбар байгууллагын тоног төхөөрөмж, барилгын сантехник, дулаан, цахилгааны шугам, сүлжээний засвар, дулаалга, үйлчилгээг хийж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангах, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах;	2021 оны 10 дугаар сарын 1-ний дотор	Байгууллагын төсвөөр	Салбарын бүх байгууллага
3.	Өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах ажлыг зохион байгуулах;	Тогтмол	-	Салбарын бүх байгууллага
4.	Албан хаагчдыг өвөлд бэлтгэх, онцгой үед ажиллах, мэдээлэл шуурхай дамжуулах зохион байгуулалт, техникийн бэлэн байдлыг хангах зэрэг чиглэлээр холбогдох албан хаагчдад сургалт зохион байгуулах;	2021 оны 09 -р сард	Байгууллагын төсвөөр	Салбарын бүх байгууллага
5.	Он дамжин үргэлжлэх бүх төрлийн барилга байгууламжийг өвлийн зогсолт хийх үеэр осол аваар гарахаас сэргийлсэн арга хэмжээг авах, шаардлагатай тэмдэг байрлуулах, сэргээх, хамгаалалт хийх;	2021 оны 10 дугаар сарын 30-ны дотор	Гүйцэтгэчийн зардлаар	Гүйцэтгэгч компаниуд
6.	Техник хэрэгслийг өвлийн горимд шилжүүлэх, холбогдох үзлэг, шалгалтыг хуваарь гарган гүйцэтгэх;	2021 оны 10 дугаар сарын 30-ны дотор	-	ИНЕГ, АТҮТ, ЗТХТ, УБТЗ, МТЗ
7.	Өвөлжилтөд шаардлагатай худалдан авах гэрээг байгуулах, гүйцэтгэлийг бүрэн хангаж дуусгах.	2021 оны 10 дугаар сарын 30-ны дотор	-	Салбарын бүх байгууллага
8.	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцыг салбарын нэгдсэн ажлын хэсэгт тогтмол тайлагнах;	Сар бүрийн 25-ны дотор	-	Харьяа байгууллагууд
<b>ХОЁР. АВТОТЭЭВРИЙН ЧИГЛЭЛЭЭР</b>				
1.	Төв болон орон нутгийн салбар төвүүдийн тоног төхөөрөмж, барилгын сантехник, дулаан, цахилгааны шугам сүлжээний засвар, дулаалга үйлчилгээг хийж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангах;	2021 оны 09 дүгээр сар		"АТҮТ" ТӨҮГ

2.	Үйлдвэрийн газрын захирлын 2019 оны А/142 дугаар тушаалаар баталсан "Ажлын хувцас нэг бүрийн хамгаалах хэрэгслийг захиалах, олгох, хэрэглэх, хянах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;	2021 оны 10 дугаар сард	"АТУГ" ТӨҮГ
3.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн сэдвээр сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах	Сар бүр	"АТУГ" ТӨҮГ
4.	Үйлдвэрийн газрын тээврийн хэрэгслүүдийг өвөлд бэлтгэх;	2021 оны 10 дугаар сар	"АТУГ" ТӨҮГ
5.	Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудаас 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангасан талаарх ажлын мэдээ тайланг сар тутамд авч ажиллах;	Сар бүрийн 20-ны өдрийн дотор	"АТУГ" ТӨҮГ
6.	Улс, хот хоорондын нийтийн зорчигч болон улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцыг газар дээр нь шалгаж, техникийн бэлэн байдлыг хангуулах, сааталгүй үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	2021.08.25-аас 09 дүгээр сарын 25	"АТУГ" ТӨҮГ
7.	Замын нөхцөл байдал хүндэрч халтиргаа гулгаа үүссэн үед хот хооронд нийтийн зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж шуурхай зохицуулалт хийх;	Тогтмол	"АТУГ" ТӨҮГ
8.	Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран "Өвөлд бид бэлэн өдөрлөг"-ийг зохион байгуулах;	2021 оны 10 дугаар сарын эхний 10 хоногт	"АТУГ" ТӨҮГ
<b>ГУРАВ. АВТО ЗАМЫН ЧИГЛЭЛЭЭР</b>			
1.	Улсын чанартай авто зам, гүүрийн засварын ажлыг батлагдсан график, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн байх;	Улсын төсөв 2021.10.30-ны дотор	"ЗТХТ" ТӨҮГ
2.	Үерийн улмаас эвдэрсэн улсын чанартай авто зам, замын байгууламжуудыг сэргээн засварлах ажлыг зохион байгуулах;	Улсын төсөв 2021.10.30-ны дотор	"ЗТХТ" ТӨҮГ
3.	Цаг агаарын хүндрэлийн үед ажиллах Улсын чанартай авто зам дээр ажиллах "Шуурхай ажлын хэсэг"-ийг сайдын тушаалаар батлуулж шаардлагатай зохион байгуулалтыг хийх;	Төлөвлөсөн зардлаар 2021.11.01-ны дотор	"ЗТХТ" ТӨҮГ
4.	Халтиргаа гулгаа үүсдэг зам, даваануудад хуурай элс, үнсийг нөөцлүүлэх, байршуулж бэлтгэх, хяналт тавих;	АЗЗА компаниуд өөрсдийн зардлаар 2021.11.01-ний дотор	ЗТХТ, АЗЗА ТӨХК-иуд
5.	Өвлийн улиралд хүндрэл үүсдэг зам даваанд цаснаас хамгаалах далан байгуулах;	2021.10.25-ны дотор	"ЗТХТ" ТӨҮГ
6.	Улсын чанартай авто замын онцгой хүндрэлтэй хэсгүүдэд түр зам гаргах, чиглэл заасан тэмдэг тавих;	Тухай бүр	"ЗТХТ" ТӨҮГ
7.	Он дамжин хэрэгжих авто зам, гүүр, их засвар, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэх компаниудын хариуцсан объектын өвөлжилтийн бэлтгэлийг өвлийн улирлын туршид хийгдэх арчлалт, анхааруулах тэмдэг, хаалт байршуулах, ХАБЭА-г хангах;	2021 оны 10 дугаар сар	Гүйцэтгэгчийн зардлаар "ЗТХТ" ТӨҮГ

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ ТЭЭВЭРИЙН ХЭВЭЖЛИЙН ЯАМ

ЭХ ХУВЬ


Салд Төрийн мэргийн бичгийн  
дэргэд: *Б.Оюун* Тухайн тушаал

		2021.10.15-ны дотор	Улсын төсөв	"ЗТХТ" ТӨҮГ
8.	Төлбөр авах цэгүүдийн өвөлжилтийн бэлэн байдлыг хангуулах, түлээ, нүүрсээр хангах, гадна зам талбайн засвар, тохижилт, гэрэлтүүлэг, замын тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбарыг сайжруулах зэрэг ажлыг зохион байгуулах;	2021.10.30-ны дотор	Замын сангийн хөрөнгөөр	"ЗТХТ" ТӨҮГ
9.	Шардлагатай үед хэрэглэгдэх цэвэрлэгээний багаж хэрэгсэл /галын хор, хүрз, давс, хайлуулах бодис, түр тэмдэг, лоом, шуудай г.м/ байнгын бэлэн байдалд байлгах;	2021.10.30-ны дотор	ЗТХТ ТӨҮГ	"ЗТХТ" ТӨҮГ
10.	Төлбөр хураах цэгийн хөдөлмөр хамгааллын дулаан хувцас, гутлаар хангах;	2021.11.01-ний дотор	ЗТХТ ТӨҮГ	"ЗТХТ" ТӨҮГ
1.	Шуурхай ажилд гарах автомашинуудын бэлэн байдлыг хангах;	2021.10.30-ны дотор	ЗТХТ ТӨҮГ	"ЗТХТ" ТӨҮГ
2.	Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, хадгалалтын нөхцлийг сайжруулах;	2021.10.10-ны дотор	Улсын төсөв	"ЗТХТ" ТӨҮГ
3.	Авто замын засвар арчлалт хариуцсан компаниудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, хуваарьт шалгалт хийх;	2021.09.01-ний дотор	ЗТХТ ТӨҮГ	"ЗТХТ" ТӨҮГ
4.	Ажлын байрны халаалт, дулаан авах асуудлын бэлтгэлийг хангаж, дулаан алдагдалтыг бууруулж, цонх хаалгыг дулаалах;	2021.10.30-ны дотор	ЗТХТ ТӨҮГ	"ЗТХТ" ТӨҮГ
5.	Гараажийн хаалгыг автоматаар онгойдог хаалгаар солих, дэвээр засварлах, гарааж доторх засвар үйлчилгээг хийх;	2021.10.30-ны дотор	ЗТХТ ТӨҮГ	"ЗТХТ" ТӨҮГ
6.	Цонх тавцанг PVC хавтангаар сольж өрөөнүүдэд будаг, замаск, эмульс ажил хийж засвар үйлчилгээг хийх;	2021.10.30-ны дотор	ЗТХТ ТӨҮГ	"ЗТХТ" ТӨҮГ

#### ДӨРӨВ. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЧИГЛЭЛЭЭР

##### 4.1 Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэг

1.	Төв болон орон нутгийн салбар байгууллагын тоног төхөөрөмж, барилгын сантехник, дулаан, цахилгааны шугам, сүлжээний засвар, дулаалга, үйлчилгээг хийж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангах, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах;	2021.10.01-ны дотор	873,241	"УБТЗ" ХНН ГТХЗНТ УТУГ
2.	Анхны өвөлд ажиллагсдын сургалт зохион байгуулах;	2021.09.20-ны дотор	Батлагдсан зардлын хүрээнд	"УБТЗ" ХНН, ГТХЗНТ УТУГ
3.	Өвлийн улиралд ажиллахгүй төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн машин механизм эвлийн горимд шилжүүлэн хадгалах хамгаалах, хэрэгжилтэд хяналт тавих;	2021.10.01-ны дотор	Урсгал зардлаар	"УБТЗ" ХНН, ГТХЗНТ УТУГ
4.	Өвөлжилтөд шаардлагатай худалдан авах гэрээг байгуулах, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах;	2021.09.25-ны дотор	5,185,412	"УБТЗ" ХНН,
5.	Нүүрсний хангалтыг тасралтгүй хуваарийн дагуу хангах;	2021.12.01-ны дотор	4,451,156	"УБТЗ" ХНН,
6.	Зорчигчийн вагоны техникийн бэлэн байдал, засвар, зэхэлтийн аж ахуйг өвөлд бэлтгэх, хэрэгжилтэд хяналт тавих;	2021.10.01-ны дотор	25,665	"УБТЗ" ХНН, ГТХЗНТ УТУГ
7.	Ачааны вагон паркийг өвлийн тээвэрт бэлтгэх, өвлийн бэлтгэл ажлыг хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	2021.10.01-ны дотор	658,281	"УБТЗ" ХНН,




8.	Зүтгүүрийн паркыг өвлийн тээвэрт бэлдэх, өвлийн түлшээр хангах, аж ахуйг өвөлд бэлдэх, хэрэгжилтэд хяналт тавих;	2021.10.01-ны дотор	"УБТЗ" ХНН, ГТХЗНТ УТУГ
9.	Төмөр замын тээвэрлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, аж ахуйг өвөлд бэлтгэх;	2021.10.01-ны дотор	178,645
10.	Төмөр замын суурь бүтцийн засвар үйлчилгээ, зам засварын техникийн бэлэн байдлыг хангах;	2021.10.01-ны дотор	1,216,118
11.	Дохиолол холбоо эрчим хүч, ус хангамжийн зэрэг аж ахуйн нэгжүүдийг өвөлд бэлдэх, хэрэгжилтэд хяналт тавих;	2021.10.01-ны дотор	9,500
12.	Эрчим хүчний байгууламжийн хэвийн ажиллагааг хангах;	2021.09.01-ны дотор	307,000
13.	Тасгийн хэмжээнд өвлийн бэлтгэл ажлыг хангах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	2021.10.01-ны дотор	154,654
14.	Төмөр замчдын нийгмийн үйлчилгээ сургалт хариуцсан байгууллагуудыг өвөлд бэлдэх	2021.10.01-ны дотор	415,163
15.	Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны салбар нэгжүүдийн өвлийн бэлтгэлийг хангах	2021.10.01-ны дотор	181,124
<b>4.2 "Монголын төмөр зам" ТӨХК</b>			
1.	Ачааны вагонуудыг өвлийн улиралд бэлтгэх үзлэг, засварт оруулах	2021.09.15-аас 2021.10.15	Үйл ажиллагааны орлогоос
2.	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад ашиглагдаж байгаа төмөр замын зам засварын машин механизмуудыг өвлийн горимд шилжүүлэн, дулаан хучлагаар хучиж хадгалах, хамгаалах	2021.12.01-ны дотор	"МТЗ" ТӨХК
3.	"Бодь интернешнл" ХХК-д түрээсээр ашиглагдаж байгаа төмөр замын зам засварын машин механизмуудын өвлийн горимд шилжүүлэлт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих	2021.12.01-ны дотор	"МТЗ" ТӨХК
4.	Өвлийн улиралд ажиллахгүй газар шорооны машин механизмуудыг өвлийн горимд шилжүүлэн, хадгалах, хамгаалах	2021.11.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос
5.	Компанийн эзэмшлийн авто машинуудад өвлийн улирлын үйлчилгээ хийх	2021.10.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос
6.	"УБТЗ" ХНН-ийн харьяа Толгойт дахь Зам засварын машинт станцын хашаанд хадгалагдаж буй QS-650W загварын балласт цэвэрлэгч машиныг өвлийн горимд шилжүүлэн, дулаан хучлагаар хучих	2021.10.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос
7.	Зүтгүүрүүдэд өвлийн улиралд бэлтгэх үзлэг засвар хийх	2021.10.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ ТЭЭВРИЙН ХЭТ АЖИЙН ЯАМ

ЭХ ХУВЬ

Самд Төрийн Холдингийн  
дэргэд  
Төрийн Холдингийн  
Хүндэтгүүлэгч  
Төрийн Холдингийн  
Хүндэтгүүлэгч

8.	Зүтгүүрүүдэд тоормосны элсний нөөц татаж авах	2021.10.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
9.	Зүтгүүрийн депогийн барилгын дулаан алдалт, салхи сэлгэлтийг арилгах, сантехникийн хоолойнуудыг дулаалах	2021.09.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
10.	Дохиолол, холбооны хээрийн байгууламжид цанаталт чийгшилтээс хамгаалах бодисуудыг тарааж байрлуулах	2021.10.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК ГТХЗНТ УТУГ
11.	Бүх муфт, зам сумын хайрцагт үзлэг хийж илэрсэн зөрчлийг арилгаж, нүх бөглөх	2021.10.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК ГТХЗНТ УТУГ
12.	Нөөц дизель генераторын үйлчилгээг хийж өвөлд бэлдэх	2021.10.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК ГТХЗНТ УТУГ
13.	Төмөртэй өртөөний барилга байгууламжийг өвөлжилтөд бэлтгэж дулаалах	2021.09.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
14.	Халаалтын зууханд ажиллах галч дадлагажуулах /Төмөртэй өртөө/	2021.09.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
15.	Уурын зууханд нүүрс таталт хийх	2021.09.10-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
16.	Хоорондын замын уулзварын зайг хэмжих тохируулах	2021.11.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК ГТХЗНТ УТУГ
17.	Хоорондын замд цас ихээр хунгарлах газруудад цасны хаалт байрлуулах	2021.11.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК ГТХЗНТ УТУГ
18.	Өвлийн улиралд зам төмрийн сэв шалгагчийг томилох, график батлуулах	2021.11.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК ГТХЗНТ УТУГ
19.	Замын дэд бүтцийн материалын нөөц бүрдүүлэх	2021.11.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК ГТХЗНТ УТУГ
20.	Зам засварын багаж, зам өргөх домкратыг шинэчилсэн байх	2021.11.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК




21.	Хаврын паспортын үзлэгээр илэрсэн 2 ком сумын дүнийг шинээр солих	2021.10.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
22.	2500м <sup>3</sup> шебень өртөөний болон хоорондын замд мөрийн өргөн өргөсгөх, уулзварын шавар цэвэрлэх	2021.10.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
23.	Тусгаарлагч уулзваруудад үзлэг шалгалт хийж засварлах	2021.10.10-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
24.	Өртөөний 21-р зам болон замын далангийн хажуугийн ус зайлуулах хоолойн чиглүүлэх шуудуу цэвэрлэх	2021.11.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
25.	Уулын болон ус зайлуулах хоолойн чиглүүлэх шуудуу цэвэрлэх	2021.11.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
26.	Ус зайлуулах хоолой, гарамд үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгах	2021.11.15-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
27.	Талбайн гэрэлтүүлгүүдийг бүрэн хэмжээгээр асаах, хэвийн, найдвартай ажиллагааг хангах	2021.11.10-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
28.	Нөөц дизель генераторын үйлчилгээг хийж өвөлд бэлдэх	2021.11.10-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
29.	Цэций өртөө болон 1,2,3,4,5,6-р зөрлөгийн шилэн кабелийн худгийг цэвэрлүүлэх	2021.10.01-ны дотор	Үйл ажиллагааны орлогоос	"МТЗ" ТӨХК
30.	Ухмал руу хүн, мал, автомашин орохоос хамгаалж хийсэн суваг, далан, анхааруулах тэмдгийг шалгаж сэргээх, шаардлагатай тохиолдолд шинээр байршуулах	2021.11.15-ны дотор	Төслийн санхүүжилтээс	"МТЗ" ТӨХК
31.	Хоорондын замын элсэнд дарагдсан зам болон хоолойн оролт гаралтыг цэвэрлэх	2021.11.15-ны дотор	Төслийн санхүүжилтээс	"МТЗ" ТӨХК
32.	Өртөө, зөрлөгүүдийг төвийн цахилгаан эрчим хүчээр хангах /төслийн санхүүжилтээс 100 хувь хамаарна/	2021.11.15-ны дотор	Төслийн санхүүжилтээс	"МТЗ" ТӨХК
33.	Өртөө, зөрлөгүүдийг өвлийн нөхцөлд түлээ, нүүрс болон түлшээр хангах	2021.09.10-ны дотор	Төслийн санхүүжилтээс	"МТЗ" ТӨХК
34.	Халаалтын зууханд ажиллах галч дадлагажуулах	2021.09.15-ны дотор	Төслийн санхүүжилтээс	"МТЗ" ТӨХК
35.	Нөөц генераторуудын үйлчилгээг хийлгэх аваарын үед бэлэн байлгах	2021.10.10-ны дотор	Төслийн санхүүжилтээс	"МТЗ" ТӨХК

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ ТЭЭРИЙН ХОГ ЖЛИЙН ЯАМ

ЭХ ХУВЬ


Сэвдэгдоржийн нарийн бичгийн дарга *Сэвдэгдорж*

9.	Техникийн газар, АТБ, Шатахууны агуулах, автобаазын цахилгаан тоолуур, гүйдлийн трансформатор шинэчлэх	III улиралд	"МИАТ" ТӨХК
10.	КТПН 6/0,4 дэд өртөөний засвар үйлчилгээ	III улиралд	"МИАТ" ТӨХК
11.	Дизель генераторт үзлэг хийлгэх	III улиралд	"МИАТ" ТӨХК
12.	Гадна гэрэлтүүлэг, прожектор засварлах, үйлчилгээ хийх	III улиралд	"МИАТ" ТӨХК
13.	МИАТ ХК-ийн 2-р байр, баталгаат агуулахын цахилгаан хэрэглээг дизель генератораас хангах	III улиралд	"МИАТ" ТӨХК
14.	Автобаазын цахилгааны урсгал засварын ажлууд	III улиралд	"МИАТ" ТӨХК
15.	ДДТ хэрэгцээний халуун усны хурдны бойлерийг ялтсан бойлероор солих, шинэчлэх	III улиралд	"МИАТ" ТӨХК
16.	Хэрэгцээний халуун усны үл буцах клапан, холбогдох шугам хоолой солих	III улиралд	"МИАТ" ТӨХК
17.	Үйлчилгээний автобаазын диспетчрийн өрөөний халаалтын шугам хэсэгчилэн засварлах	III улиралд	"МИАТ" ТӨХК
18.	Дулааны уезель болон худгуудад хаалт, шугам солих	III улиралд	"МИАТ" ТӨХК
19.	ЦТП халаалтын насос засварлах, үйлчилгээ хийх,	III улиралд	"МИАТ" ТӨХК
20.	Усны тоолуурууд баталгаажуулах	Бүтэн жилээр	"МИАТ" ТӨХК
21.	Бохир усны бүх шугамыг угаах, худгийг лайдаж цэвэрлэх	III улиралд	"МИАТ" ТӨХК
22.	Нийт барилгуудын дотор халаалтын систем угаах	III улиралд	"МИАТ" ТӨХК
23.	Ялтсан болон хурдны бойлер задлаж цэвэрлэгээ, үйлчилгээ хийх	III улиралд	"МИАТ" ТӨХК
24.	Цоорсон халаалтын шугамуудыг нөхөж оруулга хийж хэсэгчлэн засварлах	III улиралд	"МИАТ" ТӨХК
25.	Урьдчилан тооцох боломжгүй засварын ажил	III улиралд	"МИАТ" ТӨХК
26.	De/Anti-icing сэдэвт сургалтыг талбайн үйл ажиллагаа, хяналтын ажилтнуудад зохион байгуулах	III улиралд	"МИАТ" ТӨХК
27.	Мөстөлтийн үед хэрэглэх механик багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган, бэлэн байдлыг хангах	2021.11.01-ний дотор	"МИАТ" ТӨХК
28.	Оффис, цехүүдийн агаар солилцооны айркондейншнүүдийн техник үйлчилгээ, тохиргоо хийлгэх	III улиралд	"МИАТ" ТӨХК





29.	Ангаарын болон АТБ-ын ариун цэврийн өрөөнүүд, душны өрөөний хаалга шинэчлэх, холигч болон холбоосууд, агааржуулалтын хоолой мотор солих	III улиралд	"МИАТ" ТӨХК
30.	Халаалт дулаан: Ангаарын халаалтын винтляторын системийн калифер нэмэх, цэвэрлэх, засварлах	III улиралд	"МИАТ" ТӨХК
31.	Халаалт дулаан АТБ -муудаж барихгүй байгаа хаалтуудыг солих/ф200*2ш, ф50*2ш/	III улиралд	"МИАТ" ТӨХК
32.	Ариутгал татуурга: бохирын худгууд лайдах, танкны аманд шүүлтүүр тавих	III улиралд	"МИАТ" ТӨХК
33.	Цахилгаан: агаарын хөлгийн гадна зогсоолын газрын гэжээл засах, сэлбэг, Ангаарын даралтат агаарын системийн техник үйлчилгээг хийж шүүрнүүдийг солих, шугамын бүрэн бүтэн байдлыг 34шалгах, шаардлагатай хэсгүүдэд дулаалга хийх	III улиралд	"МИАТ" ТӨХК
34.	Ангарын цахилгааны сүлжээ, шугам, залгууруудын аюулгүй байдлыг хангах, агаарын хөлгийн зогсоолын гэрэлтүүлэг засвар үйлчилгээ хийж өвлийн ашиглалтанд бэлдэх, тоног төхөөрөмжүүдийн залгуурууд /вилка, розетка/, цахилгааны кабель, шатсан гэрэл, прожектор, гэрлийн унтраалга муудсан тул шаардлагатай материалыг захиалж солих, нөөцтэй болох	III улиралд	"МИАТ" ТӨХК
35.	Өвлийн улиралд цас мөс цэвэрлэх хүрээ, шүүр бусад	III улиралд	"МИАТ" ТӨХК
36.	Ангарын ажилчид нэвтрэх хэсгийн халаалтын тенг, гутлын цас мөс арилгагч, шалавч резин	III улиралд	"МИАТ" ТӨХК
37.	Б-737, 767 агаарын хөлгийн техник үйлчилгээ, засварын ажлын үед ашиглах Докнууд, бүх төрлийн шатнуудыг өвлийн улиралд ашиглах техник үйлчилгээ, засварын ажлуудыг хийж аюулгүй байдлыг хангах /шаардлагатай дугуй, тавцан, гишүүр, зөөлөвчүүдийг солих/	III улиралд	"МИАТ" ТӨХК
38.	Genie цахилгаан болон Дизель шатнуудын батерейг шалгах, цэнэглэх залгууруудыг салгаж шинэчлэх ажил хийх, шаардлагатай шингэний шланг, труп, батерей, шүүр, тос, цэнэглэх блокнуудыг солих, нөөцийг захиалах	III улиралд	"МИАТ" ТӨХК
39.	Газрын тоног төхөөрөмж: өргөх төхөөрөмжүүд, дугуй солих өргөгч, агаарын хөлгийн чирдэг водилуудад техник үйлчилгээхийг, өвлийн улиралд ашиглахад бэлдэж зориулалтын шингэн, тос, дугуй, олгой солих	III улиралд	"МИАТ" ТӨХК
40.	Эд анги хөдөлгүүрийн хучлага: агаарын хөлгийн хөдөлгүүр, агаарын халаагч, газрын тоног төхөөрөмжийн бүрээс бүтээлэг	III улиралд	"МИАТ" ТӨХК
<b>5.3 "ХӨШГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ" ТӨХХК</b>			
1.	Байгууллагын халаалт, дулаан, барилга байгууламжийн хана, цонх, хаалганы дулааны алдагдлыг тооцож, арилгах арга хэмжээ авах	2021.08.16-ны дотор	"ХХНОБ" ТӨХХК
2.	Төрийн хүндэт зочны танхимын халаалт, хана, цонх, хаалганы дулаалгыг шалгаж, холбогдох байгууллагад мэдэгдэж засварлуулах	2021.09.06-ны дотор	"ХХНОБ" ТӨХХК



3.	Зочдын автомашиныг байрлуулах зам, талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг, өвөлжилтийн хугацаанд явуулах байгууллагын удирдлагатай уулзаж, бэлтгэлийг хангуулах	2021.08.25-ны дотор	"ХХНОБ" ТӨХХК
4.	Хамтарсан компанийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай холбоо тогтоон хамтран ажиллах ажиглах, хэлцэл хийхэд дэмжлэг үзүүлэх	Тухай бүр	"ХХНОБ" ТӨХХК
5.	Компанийн эзэмшлийн автомашинуудыг байрлуулах дулаан зогсоолын аюулгүй байдал дулааныг судалж, түрээслэх, гэрээ байгуулах	2021.08.16-ны дотор	"ХХНОБ" ТӨХХК
6.	Компанийн эзэмшлийн автомашинуудад өвлийн тослоо, үйлчилгээ хийлгэх	2021.09.06-ны дотор	"ХХНОБ" ТӨХХК
7.	Барилга, байгууламжийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлгэх	Тухай бүр	"ХХНОБ" ТӨХХК
8.	Өвөлжилтийн бэлтгэл хангах талаар зохион байгуулсан ажлын тайланг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлэх	Тухай бүр	"ХХНОБ" ТӨХХК

**ЗУРГАА. УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ЧИГЛЭЛЭЭР**

1.	Хөвөлтийн улирлыг зогсоох шийдвэрийн дагуу усан замын тээврийн хэрэгслүүдийг уснаас гаргах талаар аж ахуйн нэгж, иргэдэд чиглэл өгөх ажлыг зохион байгуулах, усан замын тээврийн хяналтын зориулалттай катер болон аврах завинуудыг өвлийн зогсоолд байршуулах, хяналтын катер, аврах завинуудын 0 зогсолт хийх холбоотой засвар, үйлчилгээний ажлыг хийх	2021 оны 10 дугаар сард	Далайн захиргаа
2.	Хяналтын байрны цахилгаан, дулаан, сантехникийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг ханган харуул, хамгаалалт хариуцсан ажилтанд хүлээлгэн өгөх	2021 оны 10 дугаар сард	Далайн захиргаа
3.	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцыг салбарын өвөлжилтийн бэлтгэлийг хангах Ажлын хэсэгт тайлагнах	Сар бүрийн 25-ны дотор	Далайн захиргаа
4.	Усан замын тээврийн хэрэгслүүдийг уснаас гаргах талаар олон нийтэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулах	2021 оны 9-10-р сард	Далайн захиргаа

